



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/165

Эрдэнэт

Үзлэг шалгалт хийх, аян зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/е/, 29.2, Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 3/653 тоот албан бичгийн дагуу "Аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг ажлын байрандаа мөрдөцгөө" уриан дор эрүүл аюулгүй ажлын байр бий болгох, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, мэдээлэл сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилтын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэг сарын аяныг 2017 оны 04 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Сарын аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэнд үзлэг шалгалт хийх комиссыг хоёрдугаар, үзлэг шалгалтын удирдамжийг гуравдугаар, аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах зардлыг Хөрөнгө оруулалтын зардлын жагсаалтын "ХАБЭА-н зөвлөл болон Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах салбар хорооны үйл ажиллагааг дэмжиж ажиллах" зардлаас батлагдсан хуваарийн дагуу гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н. Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

4. Сарын аяны дүнг 2017 оны 05 дугаар сарын 10-ны дотор багтаан Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл /н.Түвшинжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

02000 0850

Аймгийн Засаг даргын 2017 оны
4 дүгээр сарын 5 өдрийн 43 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

“АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ ЖУРМЫГ АЖЛЫН БАЙРАНДАА МӨРДӨЦГӨӨ”
УРИАН ДОР ЯВАГДАЖ БУЙ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН
САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	ХНХЯ-наас ирүүлсэн ажлын чиглэл	Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	Хугацаа	Хариуцах хүн	Төсөв /төгрөг/	Хамтран ажиллах байгууллага, хамрах хүрээ
1	Сарын аяны нээлт хийх	“ХАБЭА-н сарын аян-2017” сарын аяны тухай хэвлэлийн бага хурал зохион байгуулах	6/IV	А.Түвшинжаргал Г.Ганцэцэг М.Батцоож Ц.Уранчимэг Г.Эрдэнэбулган		ААНБ, хэвлэл мэдээллийн байгууллага
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журам, стандартын талаар мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх	ААНБ-уудад сарын аян зохион байгуулах, тайланг ирүүлэх тухай албан тоот хүргүүлэх, мэдээлэл цуглуулах	IV/1-5		20,000	ААНБ-ууд
		“ХАБЭА-н хөтөч” цүнхийг аж ахуй нэгж байгууллагуудаар аялуулах	IV/1-28	Ц.Уранчимэг Г.Баасанбилэгт Д.Эрдэнэбаяр	30,000	ААНБ-ууд
		Шторк, видео бичлэг бэлтгэн телевизээр сурталчлах	IV/1-28	Ц.Уранчимэг Г.Баасанбилэгт Сарантуяа	1,000,000	ETV телевиз Номин, ЛХА, MBS
3		ААНБ-уудад ХАБЭА-н илгээх хуудас, талархал хүргүүлэх	IV/1-5	Г.Эрдэнэбулган З.Соёлмаа Ж.Баяртогтох Ц.Уранчимэг		ААНБ-ууд
4	ААНБ-ын удирдлага, ХАБЭА-нажилтныг оролцуулсан сургалт, семинар, ярилцлага, үзүүлэх сургууль зохион байгуулах	Баян-Өндөр, Жаргалант сумын ХАБЭА-н зөвлөл, ҮОХХСБК-ын гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	IV/14	З.Соёлмаа Г.Эрдэнэбулган Г.Ганцэцэг	250,000	ААНБ-ууд
		ХАБЭА-н зөвлөлгөөнийг Эрдэнэт үйлдвэрийн ХАБЭА-н хэлтэстэй хамтран зохион байгуулах	IV/19	Г.Эрдэнэбулган З.Соёлмаа Г.Ганцэцэг Ц.Уранчимэг Г.Баасанбилэгт	350,000	Эрдэнэт үйлдвэр, ААНБ-ууд
5	Эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгож, ажилчдынхаа эрүүл мэнд, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн асуудалд анхаардаг	Хамтын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, ХАБЭА-н орчныг сайжруулан ажиллаж шилдэгээр шалгарсан ААНБ-уудын туршлагыг дэлгэрүүлэх,	V/21	Г.Эрдэнэбулган З.Соёлмаа Ц.Уранчимэг Ж.Баяртогтох		1.“ЭБЦТС” ТӨХК 2.“Эрдэнэт-ус” ДТС ОНӨХК 3.“ЭДЦС” ТӨХК 4.Эрдэнэт цогцолбор

	тэргүүний байгууллага хамт олны ажлын туршлагыг дэлгэрүүлэх	сурталчлах				сургууль 5.Хүүхэд залуучуудын театр
6		Ажил олгогч эздийн холбооны Мэргэжлийн холбоодуудтай хамтран дугуй ширээний уулзалт зохион байгуулах	IV/26	М.Батцоож Ц.Сарантуяа Ж.Баяртогтох Ц.Уранчимэг	200,000	Ажил олгогч эздийн холбоо
7	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийн асуудлаар үзлэг шалгалтыг хамтран хийх	Үзлэг шалгалт явагдах тухай, зөрчигдөж байгаа асуудлын талаар мэдээлэл авах нээлттэй утас ажиллуулж санал гомдлын мөрөөр ажиллах	V/05-20	Үзлэг шалгалтын ажлын хэсэг	2,600,000	МХГ, Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс,
		Үзлэг шалгалтын дүнг нэгтгэх	V/30	Ц.Уранчимэг М.Батцоож Л.Цэдэнсодном		
		Явцын талаар мэдээ өгөх	IV/01- V/01	Ажлын хэсгийн гишүүд		Хэвлэл мэдээллийн байгууллаг ууд
8	Сарын аяны үеэр хийж байгаа ажлынхаа талаар төв орон нутгийн радио, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах	Орон нутгийн радио телевиз, вэб сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах	IV/1- 28	Ажлын хэсгийн гишүүд		ААНБ, хэвлэл мэдээллийн байгууллага
9	ХАБЭА-н дэлхийн өдөр 4 дүгээр сарын 28	Үйлдвэрлэлийн ослоор нас барагсдын дурсгалыг хүндэтгэх өдрийн үйл ажиллагааг хэмжээг "ЭДЦС" ТӨХК дээр зохион байгуулах	VI/28	Ажлын хэсгийн гишүүд		ААНБ хэвлэл мэдээллийн байгууллага
10	ХАБЭА- сарын аяны ажлыг дүгнэж, хаалтын арга хэмжээг зохион байгуулах	ААНБ-ын ХАБЭА- Дэлхийн өдрийг угтаж хийсэн ажлын тайланг авч нэгтгэх.	IV/28- V/5	Г.Баасанбилэгт Ц.Уранчимэг		ААНБ-ууд
11	ХАБЭА-н сарын аяны ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлэх	ХАБЭА-н сарын аяны ажлын дүнг нэгтгэж, тайланг гаргах	V/10	Г.Эрдэнэбулган Г.Ганцэцэг Ц.Уранчимэг		АЗДТГ, ХНХЯ
Нийтдүн					4,450,000	